

**МОНГОЛ, АНГЛИ ХЭЛНИЙ НИЙЛМЭЛ АВИАНЫ ҮГ
(Blended phonetic words in Mongolian and English)**

Б.Нямжав
/МУИС, ШУС/

Аливаа хэлэнд хэлний хэмнэх зарчим үйлчилж байдаг. Энэ зарчмаас үүссэн ярианы хэлний үзэгдэл болох нийлмэл авианы үг монгол, англи хэлний аль алинд нь түгээмэл байдаг бөгөөд эх хэлээрээ ярьж байгаа хүн энэхүү нийлмэл авианы үгийн утгат хэсгүүдийг нэг бүрчлэн задалж ухааран түвэггүй ойлгож чадна. Харин тухайн хэлийг хоёрдогч, гуравдагч хэл болгон сурч байгаа хүмүүсийн хувьд энэ нь нэлээд түвэгтэй юм. Тиймээс энэхүү нийлмэл авианы үг үүсэж байгаа явц хийгээд бүтцийг судлан ангилж, монгол, англи хэлээр зэрэгцүүлэн үзэхийг зорилоо.

Хүн утга санааг авиа, үсэг хоёроор илэрхийлдэг. Үсэг нь авиаг тэмдэглэх тэмдэг бөгөөд бичгийн хэлэнд хамаатай. Харин үсгээр тэмдэглэгдэх авиа нь ярианы хэлэнд хамаарах бөгөөд хоорондоо нэгдэж, хувьсаж байдаг хөдлөнги шинж бүхий амнаас гарах хийн урсгал юм.

Хүн ярихдаа авиаг хэзээ ч тус тусад нь салгаж дууддаггүй, мөн хэд хэдэн авиаг нэг зэрэг давхцуулан хэлэх боломжгүй. Харин авиануудыг цувуулан хэлдэг. Ийнхүү хэлэхийн цуваанд орсон авианууд бие биедээ нөлөөлөн хувирах, цаашлаад хурдан түргэн ярих явцад зарим авиа нь гээгдэн хураагддаг. Энэ нь хэлний хэмнэх зарчмаас үүдсэн үзэгдэл бөгөөд ингэж хураангуйлан хэлснийг тухайн хэлээр яригч хэнбугай ч ойлгон, утгат хэсгүүдийг нэг бүрчлэн задалж ухаарна. Харин уг хэлийг хоёрдогч хэл болгон сурч буй хүмүүсийн хувьд энэ нь ойлгоход нэлээн түвэгтэй байдаг. Жишээлбэл, монгол хүн ярианы энгийн хурдтай ярьж байхдаа *ирж байна уу?* гэдгийг *иржийнүү?*, *явна шүү дээ* гэдгийг *яванидээ*, *харж байгаарай* гэхийг *харжаагаарай* гэх мэтчилэн хэлдэг. Яг үүнтэй ижил, англи, америк хүн *I want to* гэдгийг *I wanna*, *could have* гэхийг *coulda*, *What are you going to do?* гэхийг *Whatcha gonna do?* гэж хэлдэг. Энэхүү үзэгдэл монгол, англи ярианы хэлэнд хэрхэн илэрч байна, ижил төстэй болон ялгаатай тал байгаа эсэх нь сонирхолтой юм.

Монгол ярианы хэлэнд байгаа энэ үзэгдлийг М.Базаррагчаа, мөн оросын монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов нар судалсан байдаг. Харин Р.И.Аванесов, Б.Д.Артендов, М.В.Панов, Л.И.Моисеев нарын эрдэмтэд орос хэлнийхээ жишээ баримтад түшиглэн уг үзэгдлийг судалжээ.

М.Базаррагчаа “Зөв дуудах зүй” /Уб., 1984/ гэдэг товхимолдоо хэлний уг үзэгдлийг зөв дуудах зүй болон авиа зүйн үүднээс авч үзэн тайлбарлахдаа, “хэлэхийн явцад нэг өргөлтөнд нэг үг орохоос гадна, хоёроос дээш үг багтан орж, авианы хувьд нэг үг мэт хэлэгдэх ёс бий. Үүнийг **авианы үг** /фонетическое слово/ гэдэг. Жишээ нь, “зурж орхиорой” гэсэн үг тус тусдаа өргөлттэй хоёр бие даасан үг байснаа сүүлчийн үг нь өргөлтөө алдсан учир өмнөх үгээ дагалдан “о” авиа гээгдэн, улмаар “р” авиа орхигдон “зурчхаарай” гэсэн нэг үг болсон байна. “Уул өөд, гол

уруу” гэхэд “өөд, уруу” гэсэн үгс өргөлтөө алдсан учир өмнөх үгэндээ захирагдан “уулаад, голлуу” гэж авианы нэг үг болон хэлэгдэнэ. Энэ мэтээр ерийн хэлэлцэхэд өгүүлбэр буюу хэлцийг айзам, авианы үг, үе болгон хэсэглэдэг. Эдгээрийн дотроос авианы үг нь зөв дуудах зүйн үндсэн нэгж болно. Учир нь,

1. Авианы үг нь авиа, бүтээвэр зэрэг нэгжийг бодвол хэлэлцэгч хүмүүст ойр дөт юм. Хэлний мэргэжлийн бус хүмүүс бүтээврийг тэр болгон задалж чадахгүй бол авианы үгийг бие биеэс нь зааглаж хэлдэг. Иймээс авианы үг, өгүүлбэр хоёр нь харилцах хэрэглүүрийн талаас хүмүүст нэлээд ойр байдаг нэгж юм.
2. Үгийн сангийн ба хэл зүйн утгын хувьд хэд хэдэн нэгжийг нэгтгэн, авианы нэг үгээр хэлдэг тал бий. Жишээ нь, “явж байсан юм” гэсэн таван бүтээврийг нэгтгэн “явжайсым” гэж авианы нэг үг болгон хэлдэг. /М.Базаррагчаа. 1977, 83-рт/

Иймээс авианы үгэнд буй авианы нэгдэх, хувьсах нь эрчимтэй байдаг. Ингэж хураангуйлан хэмнэж хэлж байгаа боловч бид утгат хэсгүүдийг нэг бүрчлэн задалж ухаарна.

Авианы үг нь дан ба нийлмэл хоёр янз байна. Жишээ нь, “Аж амьдрал нь цэцэглэж байна” гэхэд “аж / амьдарлана / цэцгэлжэйнэ” гэсэн авианы гурван үг болно. Үүний “аж”, “амьдарлана” гэдэг нь тус тусдаа илэрсэн хоёр авианы үг болно. Гэтэл сүүлчийн хоёр үг нь нийлж, нэг авианы үг болно”¹. Харин Б.Я.Владимирцов монгол хэлний авианы үгийн талаар “Өргөлт хийгээд эгшиг зохицох ёс хоёр нь авиа зүйн хувьд монгол үгийг бүтээдэг юм”² гэсэн нь дээрх тайлбартай таарч байна. Авианы үг гэдэг нэр томъёог эрдэмтэд хэрхэн тодорхойлсныг авч үзвэл, Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа нар “Авианы үг; phonetic word; фонетическое слово – хэлэхийн айзмын нэг өргөлтөнд захирагдсан хэсэг. Авианы үг нь хэл зүйн үг, үгийн сангийн үгтэй тохирч болох хэдий ч бүрэн адилтгаж болохгүй. Учир нь олон туслах үг тухайлбал, холбоос, утгвар, сул үг өргөлтгүй байдаг болохоор авиа зүйн үг болохгүй юм. Эдгээр нь өмнөх буюу хойно байгаа үгтэйгээ хамжиж авианы нэг үг болдог” гээд “... орчин цагийн монгол хэлний дагавар үг, сул үг зэрэг нь өмнөх үгийнхээ өргөлтөд захирагдан авианы нэг л үг болдог. Хэлэхийн явцад нэг өргөлтөнд нэг ба хэд хэдэн дагац үгийг нэгтгэн хэлц ялгах, бүтээх нэгжийг авианы үг гэнэ. Жишээ нь: *Сар шиг /дугаргий// сам шиг /садархай// /тооно/: Цаг үе /өнгөрч байгаа юм биш/, харин бид /өнгөрч байгаа юм шүү// (Карлейль), Юу гэсэн үг вэ? зэрэг жишээний “сар-шиг, сам-шиг, өнгөрчайгаам-биш, өнгөрчайгаам-шүү, юүгсүүгүв? гэж” шиг, байгаа юм шүү, байгаа юм биш, гэсэн үг вэ? зэрэг үгс нь өргөлтөө алдаж, өмнөх гол үгийн өргөлтөнд захирагдан нэг үг болон хэлэгдэнэ. Үүнийг авианы үг гэнэ. Эхний жишээ нь агуулгын хувьд зургаан үгээс бүтсэн бол хэлбэрийн хувьд авианы дөрвөн үгээс бүтжээ”³ гэж дэлгэрэнгүй тайлбарлажээ.*

Мөн Б.Д.Артедов “Хэлэхийн айзам нь авианы үг болон задарна” гээд “Орос хэлний “а- он, на-стол, на-берег зэрэг нь авианы үг болно”⁴ гэсэн бол О.С.Ахманова “Утгын дотоод холбоогүй хэл ярианы хэрчмийг авианы үг гэнэ”⁵ гэж тодорхойлжээ.

Ийнхүү хоёроос дээш үг, мөн салангид бичигдэх бүтээврүүд ярианы хэлнээ нэг

¹ М.Базаррагчаа, “Зөв дуудах зүй”, Уб., 1984, 9-10-р тал

² Владимирцов.Б.Я, “Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика”, лгр., 1929, 130-р тал

³ Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа, “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”, Уб., 2014, 7-р тал

⁴ Б.Д.Артедов, “Фонология современного русского литературного языка”, Кишинев, 1979, 7-р тал

⁵ О.С.Ахманова, “Словарь лингвистических терминов”, м., 1966, 423-р тал

өргөлтөд захирагдан нэг бүхэллэг нэгж болон хэлэгдэхдээ үе болон авиа гээгдэн хураагдахдаа авиа ижилсэн ондооших нь зүй ёсоор бий болдог байна. Энэ тухай дээрх толинд “... Ихэвчлэн дагаж, эсвэл угтаж орж байгаа үгийн бодит утга алдарч хийсвэрлэснээс авианы үг үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг, өөрөөр хэлбэл, агуулгад гарсан өөрчлөлт нь хэлбэртээ зохих ёсоор нөлөөлдөг ажээ. Авианы үг нь өргөлт бүхий нэг үе ба өргөлтгүй хэд хэдэн үгээс бүтдэг бол айзам нь гол, гол бус /дэд/ өргөлттэй үеүдээс бүтдэг... Монгол хэлний авианы үгийн гол шинж гэвэл, өргөлтөд үеийн эгшигтэй өргөлтөт бус үеийн эгшгүүд ижилсэхийн зэрэгцээ, ондоошин зохицох ёс хийгээд гийгүүлэгч гийгүүлэгчтэй, эгшиг нь гийгүүлэгчтэй зохицох ёс юм”⁶ гэж дурджээ.

Англи хэлний ийм үзэгдлийг *reduction* (балархайшил, хураах), *elision* (балархайшил, гээгдэх, эцсийн эгшиг гээгдэхүй), *contraction* (хураангуйлах) гэх мэт нэр томъёогоор нэрлэсэн байдаг бөгөөд эдгээр нь хоорондоо ижил төстэй юм шиг боловч бага зэргийн ялгаа, онцлогийг агуулж байдаг. Тухайлбал, *elision* гэдэг нь латин хэлний *elisio* “сугарах, түлхэх, шахаж гаргах” гэдэг үгээс үүсэлтэй бөгөөд ярианы урсгалд үг хэллэг дэх нэг эсвэл хэд хэдэн авиа (эгшиг, гийгүүлэгч, үе гэх мэт) орхигдон гээгдэж, уг үг хэллэгийг дуудахад илүү хялбар болох үзэгдлийг хэлнэ. Үүнийг академич Д.Төмөртоогоо “үгийн эцсийн эгшиг гээгдэхүй”, Д.Энхбат “эцсийн гийгүүлэгч балархайшил (гийгүүлэгч гээгдэлт)”, Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа нар “эцсийн эгшиг гээгдэхүй” гэж дүйлгээд “Ард байгаа эгшгээр эхэлсэн үгийн өмнөх үгийн эцсийн эгшиг гээгдэх үзэгдэл ... Эцсийн эгшиг гээгдэхүй; *elision*; элизия хэмээх нэр томъёог мөн хагаслал /*ellipsis*, эллипсис/, авиа орхих (үеийн) гэх утгаар хэрэглэдэг” хэмээн тайлбарлажээ. Харин Оксфордын хэл шинжлэлийн нэр томъёоны товч тайлбар толинд “1. үгийн төгсгөлд байгаа эгшиг араас нь дагаж орсон үгийн эхэнд байгаа өөр нэг эгшигийн өмнө гээгдэх үзэгдэл. *Prodelision* буюу араас нь дагаж орсон үгийн эхэнд байгаа эгшиг гээгдэх үзэгдэл ч мөн хамаарна 2. Зарим тохиолдолд эллипсис (хагасармал өгүүлбэр)-ийг хэлнэ”⁷ гэсэн байна.

Тэгвэл, “*contraction*” гэдэг үг латин хэлний *contrahere* → *contractio* “нийлүүлэх, ойртох, ойртуулах” гэдэг үгээс гаралтай “хасах, буурах, багасгах” гэсэн утгатай үг бөгөөд хоёр ба түүнээс олон үг нийлж, нэг үг болох үзэгдлийг хэлнэ. Ингэж нийлэн дуудагдах явцад нэг эсвэл хэд хэдэн авиа гээгдэнэ. Үүнийг доктор Д.Энхбат “агшихуй (агшил), хураангуйлал”⁸ гэж дүйлгэжээ. “*Contraction*” гэсэн үгийг Оксфордын хэл шинжлэлийн нэр томъёоны товч тайлбар толинд “*fusion* буюу уусан нийлэхүй, зааг арилахуй” хэмээх үгтэй утга агуулга адил гэж үзсэн байх ба дараах тайлбарыг хийжээ. Үүнд, “Жишээлбэл, эртний грек хэлний хураангуйлсан үйл үгсийн хувьд эгшгээр төгссөн үгийн үндэс нь араас нь орж буй дагаврын эгшигтэй нийлэх”⁹ хэмээсэн байна.

Харин “*reduction*” гэдэг нь латин хэлний *reducere* → *reductio* “буцаах, сэргээх” гэдэг үгээс гаралтай бөгөөд ярианы урсгалд үг хэллэг дэх авиа гээгдэн хураагдах үзэгдлийг хэлнэ. Энэхүү нэр томъёо нь зарим талаараа *elision*, *contraction* -ны жишээг багтаасан байдгаас үзвэл илүү ерөнхий утгатай мэт. Харин Чой.Лувсанжав, Ч.Зээнямбуу, Д.Энхбат, Д.Төмөртоогоо нарын хэл шинжлэлийн нэр томъёоны тольд үүнийг “сулрах, балархайшил” гэж дүйлгэсэн бөгөөд Б.Ринчен балархай эгшгийг

⁶ Ч.Зээнямбуу, М.Базаррагчаа, “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”, Уб., 2014, 8-р тал

⁷ Р.Н. Matthews, “Oxford concise dictionary of linguistics”, Oxford, 2007, pg. 119

⁸ Д.Энхбат, “Хэл шинжлэлийн Англи-Орос-Монгол толь бичиг”, Уб., 2003, 57-р тал

⁹ Р.Н. Matthews, “Oxford concise dictionary of linguistics”, Oxford, 2007, pg. 78

“огцом эгшиг” гэжээ.

Тухайлбал, “Балархайшил гэдэг нь эгшиг авианы дуудлага өргөлтгүй байршлаас үүдэн сулрах, өөрчлөгдөх үзэгдэл юм. Өргөлтгүй бүх эгшиг балархайших бөгөөд өргөлттэй эгшгээс богино, сул, хүчдэл багатай дуудагдана. Орос хэлэнд өргөлтөөр утга ялгадаг бол монгол хэлний өргөлтөд эгшиг утга ялгадаггүй. Монгол хэлний гол өргөлт нь ямагт үгийнхээ тэргүүн үед, дэд өргөлт нь ерөнхийдөө хоёрдугаар үед байдаг ... Монгол хэлэнд балархай эгшиг тэргүүн үеэс хойш орсон гийгүүлэгч авиануудыг бие биеэс нь салгах, зааглах үүрэг гүйцэтгэнэ. Тэргүүн үеэс хойш тохиолдох богино эгшиг хэлэгдэх сонсдохын талаас, тод бус болохыг ‘балархайших, огцомших, сулрах’ зэргээр нэрлэсэн байдаг”¹⁰ гэснийг үзвэл балархайшил гэдэг нь өргөлтгүй байрлалд байгаа эгшиг авиа сулрах үзэгдлийг хэлж байгаа бөгөөд англи хэлэнд яг энэ ойлголтыг “vowel reduction” гэж ялгаж нэрлэсэн байдаг. Харин “reduction” гэдэг нэр томъёо нь авиа гээгдэн эсвэл сугаран богиносч, хураагдан хэлэгдэх төдийгүй хэлний бусад нэгжийн хувьсал өөрчлөлтөд ч хамаатай ажээ.

Дээрх нэр томъёоны тодорхойлолтууд болон жишээ тайлбаруудаас үзвэл ярианы урсгалд өргөлттэй хэлэгдэж буй үг бүр авианы үг болох бөгөөд дотроо дан, нийлмэл гэж хуваагддаг байна. Монгол хэлэнд, хэлэхийн явцад нэг өргөлтөнд хоёроос дээш үг нэгдэн орж, өргөлтөд үеийн эгшигтэй өргөлтгүй үеийн эгшгүүд ижилсэхийн зэрэгцээ, ондоошин мөн эгшиг, гийгүүлэгч зохицох ёсоор зохицон авианы хувьд нэг үг мэт хэлэгдэх үзэгдлийг **нийлмэл авианы үг** гэнэ. Англи хэлний хувьд өмнө дурдсан нэр томъёонуудаас “contraction” (хураангуйлах) гэдэг нь ярианы урсгалд заавал хоёр ба түүнээс олон үг уусан нийлж нэг үг болон дуудагдах ба ингэхдээ нэг эсвэл хэд хэдэн авиа гээгдэж болох үзэгдлийг хэлж байгаагаараа нийлмэл авианы үг гэдэгтэй илүү таарч байна. Ийм үгс ярианы монгол, англи хэлэнд түгээмэл тохиолдох авианы үзэгдэл бөгөөд үүнийг бүтээвэр дээр тулгуурлан бүтцийн талаас нь ангилан тайлбарлах юм уу эсвэл нийлж нэг үг болон хэлэгдэж буй үгсийг утга хэлбэрийн харьцаагаар нь тайлбарлаж болох юм. Монгол хэлний нийлмэл авианы үгийг ажиглавал дараах байдлаар үүсэж байна. Үүнд:

1. Бие даасан өргөлттэй үгийн араас өргөлттэй үг орох үед сүүлчийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгээ даган нийлж, нэг үг болон хэлэгдэнэ. Ингэхдээ араас нь орж, өргөлтөө алдаж байгаа үгийг ажиглавал үйл үг, туслах үг, холбоос, холбох үйл үг, дагавар үг гэх мэт байна. Жишээлбэл:

- Өргөлттэй үг + тодорхой утга бүхий туслах үг: “Цэвэрлээд орхиорой”, “үлдээж орхиорой” гэхэд тус тусдаа өргөлттэй хоёр бие даасан үг байснаа сүүлчийн үг нь өргөлтөө алдсан учир өмнөх үгээ дагалдан “о” авиа гээгдэн, улмаар “р” авиа орхигдон “цэвэрлээдхээрэй”, “үлдээчхээрэй” гэсэн нэг үг болжээ. Ингэхдээ эгшиг зохицох ёсны дагуу “-оорой” гэсэн нөхцөл нь “-ээрэй” болж, “үлдээж” гэдэг үгний “ж” авиа араас нь залган орох “х” авианы нөлөөгөөр “ч” болон хувирчээ. “Нааш ир” гэсэн хоёр үгийг харвал “ир” гэсэн үйл үг “нааш” гэсэн орны нэрийг тийн ялгалын тэг хувилбараар захирч байна. Хэлэхийн явцад сүүлийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгэндээ татагдан “наашир” гэж нэг үг болон хэлэгдэнэ. Мөн “хаа очив” гэхийг “хаачив” гэж хэлдэг.
- Өргөлттэй үг + ерөнхий утга бүхий туслах үг: “Үзэж байна” гэхийг “үзжэйнэ”, “харж байсан” гэхийг “харжайсан” гэх ба энэ нь “үзэж, харж” гэсэн гол үйл үгийн араас “байна, байсан” гэсэн туслах үйл үг орохдоо өргөлтөө алдан өмнөх үгээ дагалдан нийлж нэг үг болохдоо “б” авиа

¹⁰ Ч.Зэнямбуу, М.Базаррагчаа, “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”, Уб.,2014, 37-р тал

өмнөх “ж” авиа руу ухран ижилсэн хураагдсан байна. Мөн “үзэж” гэсэн эм эгшигтэй үгтэй “байна” гэсэн эр эгшигтэй үг нийлж хэлэгдэхдээ эгшиг зохицох ёсны дагуу хувирчээ.

- Өргөлттэй үг + холбоос: “Чоно ба туулай”, “ном буюу сургаал” гэсэн тус тусдаа авианы гурван үгийн эхний хоёр үг нь нийлж, “чоноба”, “номбуюу” гэсэн нийлмэл авианы үг үүсгэнэ.
- Өргөлттэй үг + холбох үйл үг: Хоёр үйл үгийг холбох үүрэгтэй “гэсэн” гэсэн холбох үйл үг өргөлтөө алдан өмнөх үгээ дагалдан нийлж нэг үг болдог. Жишээлбэл, “юу гэсэн үг вэ?” гэхийг “юүгсүүгүв?” гэж хэлэх ба “гэсэн үг вэ?” зэрэг үгс нь өргөлтөө алдаж, өмнөх гол үгийн өргөлтөнд захирагдан нэг үг болон хэлэгдэж байна. Хэрвээ уг “гэсэн” гэсэн холбох үйл үг өөрөө гол үйл үгийг үүргээр орвол хойноо нотлох болон асуух утгатай сул баймжит бүтээвэр авахдаа өргөлтөө алдалгүй ард байгаа үгнүүдээ өөртөө нэгтгэдэг. Жишээлбэл, “ирээрэй гэсэн юм уу?” гэдгийн “гэсэн юм уу?” нь өмнөх үгтэйгээ нийлэхгүй тусдаа хэлэгдэх ба ярианы урсгалд “гэсиймуу?” болно.
- Өргөлттэй үг + дагавар үг: “дээд, доод, урд, хойд” зэрэг орон цагийн нэрийн ард “тал” гэсэн дагавар үг ороход бид эгшиг зохицуулан “дээтэл, доотол, уртал, хойтол” гэж хэлдэг. Бид “уртал, хойтлоо хар” гэх мэтээр ярьдаг. Эндээс харахад эдгээр орон цагийн нэрийн эцсийн “д” авиа нь араас нийлэн хэлэгдэж буй үгийн “т” авиатай давшин ижилсэж улмаар сугаран хэлэгдэж байна.

2. Бие даасан өргөлттэй үгийн араас бүтээвэр (өргөлтгүй байдаг) орох үед гол үгэндээ татагдан нийлж, нэг үг болон хэлэгдэнэ. Ингэж гол үгэндээ татагдаж байгаа бүтээвэрт сул баймжит бүтээвэр, олон тоо заасан бүтээвэр, таамаглах утга илэрхийлэх бүтээвэр гэх мэт орж байна. Жишээлбэл:

Өргөлттэй үг + сул баймжит бүтээвэр: “явна шүү дээ”, “эрх юм”, “эрх юм шүү дээ”, “явж байсан юм” гэхэд орсон “юм, шүү, дээ” гэх мэт сул баймжит бүтээврүүд нь өргөлтгүй байдаг учраас хэлэхийн урсгалд өргөлтөд гол үгэндээ татагдан нийлж, “яваншд(ээ), эрхийм, эрхиймшд(ээ), явжайсым” гэсэн нийлмэл аялга үг үүсгэдэг. Ерөнхийлөн асуух “уу? үү?”, ялган асуух “бэ? вэ?” сул баймжит бүтээвр мөн л хэлэхийн явцад өмнөх үгээ даган нийлж хэлэгддэг. Жишээлбэл, “яах вэ? хэн бэ?” гэхийг “яахав? хэмб?”; “мөн үү? очих уу?” гэхийг “мөнүү? очхуу?” гэж хэлдэг. “Хэзээ очих вэ?” гэхийг “хэзээ очхов?”, “ирсэн үү?” гэхийг “ирснүү?” гэх мэтчилэн хэлдэг.

Үүнээс гадна нотлох утгатай “юм”, онцлон ялгах утгатай “л”, зэрэгцүүлэн ялгах утгатай “ч” гэх мэт сул баймжит бүтээвэр тус тусдаа өргөлттэй хоёр үгийн завсраар орж хэлэгдэх тохиолдол ч бий. Жишээлбэл, “ирэх болов уу” гэдгийн “ирэх, болов” гэсэн хоёр үгийн голоор “юм” гэсэн бүтээвэр орохоор “ирхиймболуу” гэсэн нэг авианы үг үүсэж байна. Үүнтэй ижил “явж л байна” гэхийг “явжал(б)айна”, “сурч ч байна, судалж ч байна” гэхийг “сурчич(б)айна, судалжич(б)айна” гэнэ.

- Өргөлттэй үг + олон тоо заасан бүтээвэр: “зөөгч нар”, “жолооч нар” гэхэд орсон олон тооны “нар” бүтээвэр нь өргөлтөд гол үгийнхээ эгшигтэй зохицон хувирч, “зөөхчнөр, жолоочнор” гэж нийлж хэлэгдэнэ. Энд “зөөгч” гэсэн үгийн үзүүрийн “г” авиа амьсгалын түрэлттэй “ч” авианы нөлөөгөөр “х” болон хувирчээ.
- Өргөлттэй үг + таамаглах утга илэрхийлэх бүтээвэр: “явах шиг”, “өгөх шиг”, “ ч гэх шиг” зэрэг үгийг “явахшиг, өхшиг, чихшиг” гэх зэргээр

өргөлттэй үйл үгийн ард хэлэгдэх таамаглах утгатай “шиг” бүтээвэр гол үгэндээ татагдан нийлж хэлэгдэнэ. Харин “чам шиг” гэхэд орж байгаа “шиг” бүтээвэр дээрх бүтээвэр биш, адилтгах нөхцөл бөгөөд мөн л өмнөх өргөлттэй гол үгэндээ татагдан нийлж дуудагдана.

- Өргөлттэй үг + ерөнхийлөн хамаатуулах болон чиглэл заасан тийн ялгалын нөхцөл: “цагт нь, амьдрал нь” гэхэд ерөнхийлөн хамаатуулах “нь” нөхцөл тусдаа салангид бичигддэг ч бид ярихдаа “цахтана, амьдарлана” гэж нийлмэл авианы үг үүсгэн хэлдэг. “Байр уруу, эгч уруу, уул өөд, тэнгэр өөд” гэхэд “уруу, өөд” гэсэн үгс өргөлтгүй тул өмнөх үгэндээ захирагдан, эгшиг зохицон “байрлуу, эгчлүү, уулаад, тэнгэрээд” гэж авианы нэг үг болон хэлэгдэнэ.

Үүнээс гадна “өргөлттэй үг + өргөлттэй үг + бүтээвэр (нэгээс гурван)” гэсэн дээрх хоёр бүтцийг хольсон, өөрөөр хэлбэл, хоёр өргөлттэй үгийн араас бүтээврүүд орсон нийлмэл авианы үгс байдаг. Ингэвэл мөн л дээр дурдсаны адил өргөлтөт гол үгийн араас орж байгаа өргөлтөт үг өргөлтөө алдан гол үгэндээ татагдан, түүний араас орж буй бүтээврүүд мөн өмнөх үгээ даган нийлж хэлэгдэнэ. Жишээлбэл, ерийн хэлэлцэхэд “дээд тал нь” гэхийг “дээтлэнэ”, “доод тал нь” гэхийг “доотлоно”, “нааш ир л дээ” гэхийг “наашралдаа”, “үзэж байсан юм шүү дээ” гэхийг “үзжэйсиймшдээ” гэх мэтээр хэлдэг.

3. Тус тусдаа бие даасан өргөлттэй, утга зүйн хэд хэдэн үг нийлж нийлмэл авианы үг үүсгээд сүүлдээ хэвшээд утга санаа нь нэг болчихсон үг байдаг. Жишээлбэл, “дуу гарах, өр өвдөх” гэхэд нэр үйлийн харьцаа заасан, харилцан тэгш эрхтэй, үйл үг нь нэр үгээ нэрлэхийн тийн ялгалаар захирч байгаа тусдаа хоёр үг байсны сүүлийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгэндээ татагдан “дуугарах, өрөвдөх” гэсэн нэг авианы үг болон хэвшжээ. “Өнөө өдөр, нөгөө өдөр” гэсэн тодотгогч, тодотгуулагчийн харьцаатай хоёр үгийг харвал “өнөө, нөгөө” гэсэн заах төлөөний үгийг “өдөр” гэсэн орон цагийн нэр захирсан байна. Арын “өдөр” гэсэн үг мөн л өргөлтөө алдан өмнөх үгтэйгээ нийлж “өнөөдөр, нөгөөдөр” гэсэн авианы үг үүсгэн улмаар хэвшжээ. Үүнтэй ижил “маргааш өдөр” гэдэг нь “маргаадар” болно. “Дур үгүй, тав үгүй” гэдгийн үгүйсгэх утгатай “үгүй” гэдэг үгийн “ү” авиа гээгдэн өргөлтөө алдсанаар үгүйсгэх утгатай харьцангуй тэмдэг бүтээдэг “гүй” гэсэн бүтээвэр болсноор “дургүй, тавгүй” гэсэн авианы үг үүсгэнэ. Хааяа эгшиг зохицон хувирдаг, жишээлбэл, “дуу үгүй” гэдгээс “дуугай, дугай” гэх мэт авианы үг үүсэн хэвшжээ. “Авч ирэх” гэсэн зэрэгцэн холбогдсон хоёр үйл үг “авчрах” гэсэн нийлмэл авианы үг болон хэвшсэн. Нутаг нутгийн аялгууны онцлогоос шалтгаалан үүнийг “авцрах” эсвэл “ацрах” гэж хэлэх нь ч бий.

Одоо англи хэлний “contraction” буюу “хураангуйлсан үг”-ийг авч үзье. Дээр хэлсэнчлэн энэ нэр томъёогоор илэрхийлж байгаа жишээ болон санаа нь нийлмэл авианы үг гэдэгтэй таарч байгаа юм. Англи хэлний нийлмэл авианы үгийг ажиглавал дараах маягаар үүсэж байна. Үүнд:

1. Бие даасан өргөлттэй үгийн араас өргөлттэй үг орох үед сүүлийн үг нь өргөлтөө алдан өмнөх үгээ даган нийлж, нэг үг болно. Тухайлбал:

- Үйлийн эзэн (ихэвчлэн биеийн төлөөний үг) + туслах үйл үг: энэ тохиолдолд үйлийн эзэн болох биеийн төлөөний үгийн араас түүнтэй тоогоор зохицон, цагийн утга ялгахад тусалж орж байгаа туслах үйл үг болох “to be”, “to have”, зарим нэг баймж үйл үг байх юм. Жишээлбэл, “I am” гэхийг “I’m” гэж нэг үг болгон хэлэхэд “am” –ийн “a” эгшиг гээгдсэн байна. Үүнтэй ижил “he is, she is, it is” болон “he has, she has, it has” гэхийг “he’s, she’s,

it's", "man is, that is" гэхийг "man's, that's", "you are, they are" гэхийг "you're, they're", төлөөний нэрийн ард байгаа "have" нь "ve", "had" нь "d" болж залгагдан авианы нэг үг болно. Мөн төлөөний нэрийн араас орж буй "will, shall, would" зэрэг баймж үйл үг нь өргөлтөө алдан өмнөх төлөөний үгэндээ захирагдан татагдаж, "I'll, she'll, they'd" гэх мэтчилэн нэг үг болон дуудагдана. Үүнээс гадна баймж үйл үгийн араас өнгөрсөн цагийн утга үүсгэхэд туслан орсон "have" туслах үйл үг мөн өргөлтөө алдан өмнөх баймж үйл үгээ даган нийлж, "coulda, mighta, shoulda, woulda, musta" гэх мэтээр нэг үг болон хэлэгдэх нь бий.

- Үйл үг + биеийн төлөөний үг: энэ тохиолдолд үйл үг нь гол үйл үг эсвэл туслах үйл үг байж болно. Харин биеийн төлөөний үг нь хэрвээ гол үйл үгийн араас орж байгаа бол заах болон өгөх оршихын тийн ялгалын утга ялгасан тусагдахууны үүргээр орж буй төлөөний үг байна, туслах үйл үгийн араас орж байгаа бол нэрлэхийн тийн ялгалд байгаа үйлийн эзний үүргээр орж буй төлөөний үг байна. Жишээлбэл, "let us, ask them, tell him, show her, bet you, get you, got you, want you, give me, let me" гэх мэт үгс нь "let's, askem, tellim, shower, betcha, getcha, gotcha, wancha, gimme, lemme" гэх мэт нэг үг болон хэлэгдэнэ. Америк хүн ярианы энгийн хурдаар "How are you? What are you...?" гэхийг "howaya, waddaya" гэж хэлэх бөгөөд асуух үгийн араас туслах үйл үг, түүний араас өгүүлэгдэхүүнийг заасан биеийн төлөөний үг орсон ийм цуваа бүтэц ярианы урсгалд нэг өргөлтөн дор орж нэг үг болон хэлэгдэх нь англи хэлэнд түгээмэл тохиолддог. "How do you" гэхийг "howdya", "how did you" гэхийг "howjya", "what did you" гэхийг "whajya" гэх мэтчилэн хэлдэг. Эдгээр нийлмэл авианы үгс мөн л авиа ижилсэн, ондооших, сугарах, гээгдэх гэх мэт ёсонд захирагдан хувирсан байна. Жишээлбэл, "did you" нь "jya" болсныг үзвэл "д"-ийн араас орсон "и" авиа өмнөх гийгүүлэгчээ зөөллөн, тагнайшуулснаар хамжин шүргэх "ж" болсон байна. Мөн "got you" нь "gotcha" болсныг тайлбарлавал, хатуу амьсгалын түрэлттэй "т" гийгүүлэгчийн араас дуутай гийгүүлэгч "е" орсноор мөн зөөллөн хамжин шүргэх "ч" болж хувирчээ.

2. Бие даасан өргөлттэй үгийн араас бүтээвэр орох үед бүтээвэр нь гол үгэндээ татагдан нэг үг болж хэлэгдэнэ. Тухайлбал:

- Үгүйсгэх утгатай "not" бүтээвэр туслах үйл үг болон баймж үйл үгийн араас орж, хурагдан хэлэгдэхдээ "n" болон "t" гийгүүлэгчдийн дундах "o" авиа сугаран "n't" болдог. Жишээлбэл, "isn't, aren't, wasn't, weren't, don't, doesn't, didn't, haven't, hasn't, hadn't, couldn't, wouldn't" гэх мэт.
- Англи хэлэнд өргөлттэй, өргөлтгүй үгийн араас орж буй "of", "to" угтвар буюу хийсвэр бүтээвэр нь өмнөх үгээ даган нийлж нэг үг болох үзэгдэл байдаг. Жишээлбэл, "a lot of, out of, sort of, got to, ought to" гэх мэт нь "a lotta, outta, sorta, gotta, oughta" гэж нэг болж хэлэгддгийг үзвэл "т" авиагаар төссөн үгийн араас орж байгаа "to" шууд даган нийлснээр давхарлаж орсон "т" авиаг зарим нэг хэсэг нь дан "т" шиг дуудна, нөгөө хэсэг нь давхарлаж орсон хоёр "т" авиаг дуудсанаар хэлэнд чичирхийлэл үүсэж улмаар "р" авиа шиг хэлэгдэн "go(r)a, lo(r)a" гэж байгаа юм шиг хэлэгддэг. Харин "going to, want to, trying to" гэсэн үгсийн "н" авианы араас орж буй "т" авиа нь "н" авиатай ижилсэн "gonna, wanna, trynna" гэсэн нэг үг болж хэлэгдэнэ. Үүнээс гадна "kind of" нь "kinda", "have to" нь "hafta", "has to" нь "hasta" гэж хэлэгддэг.

3. Тус тусдаа бие даасан өргөлттэй, утга зүйн болон хэл зүйн хэд хэдэн үг нийлж нийлмэл авианы үг үүсгээд сүүлдээ хэвшин, утга санаа нь нэг болчихсон үгс англи хэлэнд мөн их биш ч цөөнгүй байдаг. Жишээлбэл, “баяртай” гэсэн утгатай “goodbye” гэдэг үг нь “бурхан чамтай хамт” гэсэн утгатай “god be with you” гэсэн үгнээс үүсэн авианы үг юм. Түүнчлэн, “day’s eye” гэхийг “daisy”, “sheep herd” гэхийг “shepherd”, “fourteen-night” гэхийг “fortnight”, “loaf-ward” гэхийг “lord” гээд “of (the) clock” гэдгийг “o'clock” гэж нэг авианы үг болгон дууддаг байж байгаад улмаар бие даасан нэг үг болон хэвшжээ. Ийнхүү хэвшсэн зарим англи үг эртний англи хэлнээс үүссэн байх бөгөөд тухайлбал, “whole be thou” гэсэн гурван үг нийлж дуудагдан “hello” гэсэн авианы нэг үг болсон байх жишээтэй байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд “нийлмэл авианы үг” нь бичгийн бус ярианы хэлний үзэгдэл бөгөөд ярианы урсгалд нэг өргөлтөнд хоёр ба түүнээс олон үг нийлэн орж, нэг үг мэт хэлэгдэх үзэгдлийг хэлж байна. Энэ үзэгдэл нь монгол, англи хэлэнд түгээмэл тохиолдож байгаа бөгөөд үүсэж буй бүтцийн хувьд ч ижил төстэй байна. Авианы үг үүсэхдээ амнаас урсан гарч буй үг хэллэгийг аль болох эвтэйхэн, амар хялбар байлгахад үйлчилдэг эгшиг зохицох, гийгүүлэгч зохицох, ижилсэх, ондооших, авиа гээгдэх, сугарах ёсын дагуу хувирч хэлний хэмнэлийн зарчимд захирагдаж байна. Монгол, англи хэлний нийлмэл авианы үг үүсэж буй онцлог шинж дараах байдалтай байна:

1. Өргөлттэй үгийн араас өргөлттэй үг орох үед арын үг нь өргөлтөө алдан өмнөх үгэндээ татагдан нийлж, авианы нэг үг болж байна. Монгол хэлэнд өргөлттэй үгийн араас орохдоо өргөлтөө алдан хэлэгдэж байгаа үг нь үйл үг, туслах үг, холбоос, холбох үйл үг, дагавар үг байхад англи хэлэнд туслах үйл үг, холбоос, биеийн төлөөний үг өргөлтөө алдан өмнөх үгээ дагаж орж байна.
2. Бие даасан өргөлттэй үгийн араас орж буй бүтээвэр гол үгэндээ татагдан нийлж, нэг үг болон хэлэгдэнэ. Монгол хэлэнд уг бүтээвэр нь сул баймжит бүтээвэр, олон тоо заасан бүтээвэр, таамаглах утга илэрхийлэх бүтээвэр, ерөнхийлөн хамаатуулах болон чиглэл заасан тийн ялгалын нөхцөл гэх мэтээр илэрч байхад англи хэлэнд үгүйсгэх бүтээвэр, угтвар буюу хийсвэр бүтээврээр илэрч байна.
3. Хоёр хэлэнд хоёуланд нь дээрх аргаар нийлмэл авианы үг үүсэн улмаар хэвшин нэг үг болсон жишээ олонтоо тохиолдож байна. Үүнээс үзэхэд энэ нь гарцаагүй ярианы хэлний үндсэн шинжийн нэг юм.

НОМ ЗҮЙ

1. Артендов.Б.Д, *Фонология современного русского литературного языка*, Кишинев, 1979.
2. Ахманова.О.С, *Словарь лингвистических терминов*, м., 1966
3. Базаррагчаа.М. *Зөв дуудах зүй*, Уб., 1984.
4. Brown, G. *Listening to Spoken English*. Second Edition. London: Longman, 1990.
5. Brown, J. and A. Hilferty. *Listening for reduced forms*, 1986. *TESOL Quarterly* XX/4: 759-763
6. Brown, J. and A. Hilferty. *The effectiveness of teaching reduced forms for listening comprehension*, 1982. Paper presented at the TESOL convention, Honolulu, Hawaii

7. Brown.J. *Authentic communication: Whyzit importan' ta teach reduced forms?*, 2006. University of Hawaii at Manoa
8. Владимирцов.Б.Я, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика*, лгр., 1929.
9. Злобина И.С. *Using Reduced Forms in Spoken American English*, Россия, 2010. Филологические науки/7. Язык, речь, речевая коммуникация
10. Зээнямбуу.Ч, Базаррагчаа.М, *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*, Уб., 2014.
11. Matthews.P.H, *Oxford concise dictionary of linguistics*, Oxford, 2007.
12. Robert W. Norris. *Keeping up with Native Speaker Speed: An Investigation of Reduced Forms and Deletions in Informal Spoken English*, 1994. Article published in *Studies in Comparative Culture*, No. 25: 72-79
13. Төмөртоого.Д. *Хэл шинжлэлийн нэр томъёоны хураангуй толь*, Уб., 2004.
14. Энхбат.Д. *Хэл шинжлэлийн Англи-Орос-Монгол толь бичиг*, Уб., 2003.
15. Weinstein, N. *Whaddaya say? Guided practice in relaxed speech (2nd ed.)*, London, 2001.
16. <http://www.etymonline.com/>
17. <http://en.wikipedia.org/>

RESUME

When people speak fast or at natural speed, they often reduce or contract sounds, sometimes, syllables in a word or combined words because of linguistic economy principle. This phenomenon, which only occurs in spoken language, is named as “phonetic word” in Mongolian and “contraction” in English. These two terms denote a word that is made up of two or more words that are connected together. While the words are combined in flow of speech, some sounds of them can be transformed, weakened, dropped or lost, which is governed by some phonetic rules like assimilation, dissimilation, elision, vowel reduction, vowel and consonant harmony etc.

Generally, the structure and forming of phonetic words or contractions in Mongolian and English are almost same except some peculiarities. In both languages, the structure and general feature of those words are as follows:

- Stressed word + stressed word. In this situation, the first word usually keeps its stress, but the following word loses its stress. Therefore, it is attracted or governed by the preceding word and as a result, they come under the one stress becoming one word.
- Stressed word + morpheme. The morpheme is not stressed, so it usually follows and attached to the preceding stressed word.
- Some phonetic words, formed in the ways above mentioned, become standard and usual like a independent word.